



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 07 сарын 07 өдөр

Дугаар 266

Улаанбаатар хот

“МИК Актив Хоёр ТЗК” ХХК-д
төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдэд
томилохыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.6, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 8.1 болон Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 266 дугаар тогтоолоор батлагдсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай” журмын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “МИК Актив Хоёр ТЗК” ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр Лхагважавын Гангэрэл, Доржийн Нэргүй, Бөөхүүгийн Осоргарав, Даваагийн Баянзул нарыг томилохыг зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоолын 1-д заасан төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдэд холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг үүрэг болгосугай.

1. Энэхүү тогтоол батлагдахаас өмнө “МИК Актив Хоёр ТЗК” ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан шийдвэр, түүний хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй байхыг дурдсугай.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000276